



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№26 /240/

2022.02.08

Цаг үе, үйл явдал

БҮХ ЦЭРГИЙН ИХ ХАР СҮЛДИЙГ ЦАГААЛАХ ТАЙЛГЫН ЁСЛОЛ БОЛОВ



Бүх цэргийн Их хар сүлдийг цагаалах тайлгын ёслол өнөөдөр боллоо. Энэхүү тайлгын ёслолд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагууд оролцов. Тэнгэр заяат Чингис хаан Монгол туургатныг нэгтгэж, төр улсаа төвхнүүлэн сүр хүчээ бадруулахаар мөнх тэнгэрээс илгээсэн Цэргийн хар сүлдээ бүх Монголын

ард олон, цэрэг эрсийн оюун санааг нэгтгэн, зориг хүчийг бадруулагч, хандсан зүгтээ харгалдах дайсангүй болгож шүтээн болгон тахиж, түг түмэн цэрэг, баатар эрсийнхээ манлайд залж явсны учир түүнийг өдгөө бид уламжлан авч, Монгол Улсын тусгаар тогтнолыг батлан хамгаалагч цэрэг эрсийн оройн дээд шүтээн Бүх цэргийн Их хар сүлд болгон залж, жил бүр

цагаалах тайлгыг зохион байгуулдаг уламжлалтай. Эртнээс үеийн үед дамжин ирсэн энэхүү ёслолыг үйлдсэнээр өдгөө Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний

нийт бие бүрэлдэхүүн болон тив, дэлхийд энхийг сахиулах эрхэм хүндтэй үүргийг гүйцэтгэж буй энхийг сахиулагчдынхаа үйл хэрэг, буян заяаг даатгадаг юм.

Түүхэнд энэ өдөр

1947 он

Сайднарын зөвлөлийн тогтоолоор Барилгын 26 дугаар батальоныг барилга конторын ангийн хамт байгуулж, Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургуулийг барилгуудыг / Богд хан уулын Зайсангийн аманд/ бариулах шийдвэр гарчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,586.00	2,858.0
EUR	3,255.0	3,270.0
CNY	448.50	450.00
RUB	38.30	39.00
JPY	24.72	24.90
KRW	2.41	2.42

ЗУРХАЙ



2022.02.08 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 7/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.10-18.03

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал: Ус

ДОРНЫН ЗУРХАЙ:

Энэ өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэхэд сайн

Энэ өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, эрдэнийг гадагш өгөхөд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ХЭЭРИЙН ГАРАЛТ, БЭЛТГЭЛ СУРГУУЛИЙН ХҮРЭЭНД АЛИВАА ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын 2021-2022 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу хээрийн гаралтын дадлага, сургуулийн бэлтгэл ажилтай танилцаж, урьдчилан сэргийлэх

ажлыг зохион байгуулах комиссын хуралдаан зохион байгуулагдав. Тус хуралд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

хурандаа Б.Эрхэмбаяр, Зэвсэгт хүчний хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга хурандаа Ж.Өсөхбаяр, ЗХЖШ-ын сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга хурандаа Ш.Гантулга, Цэргийн албаны хэлтсийн дарга хурандаа Н.Лхагвасүрэн нарын албаны хүмүүс оролцлоо.

Тус хуралд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын 2021-2022 оны сургуулийн жилийн хээрийн дадлага сургуулийн хуваарь, үйл явцад тавигдах хяналт шалгалтын ажил болоод цэргийн албаны хэлтсээс хийж хэрэгжүүлэх ажлыг холбогдох албан тушаалтнууд танилцуулсан юм. Хуралын төгсгөлд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар доорх үүрэг чиглэлийг өглөө. Тодруулбал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын хээрийн дадлага сургуулийн бэлтгэл ажлыг

урьдчилан шалган тусалж, дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын хээрийн дадлага сургуулийн явцад хяналт шалгалт хийх, түүнчлэн Зэвсэг галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодистой ажиллах үеийн аюулгүй байдлыг ханган ажиллахаас гадна цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахин ажиллуулахыг анхааруулав.

Мөн "Ковид-19" цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж хээрийн дадлага, сургуулийн үед соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах, гарч болзошгүй аливаа эрсдэлийг тооцож ажиллах, хээрийн дадлага сургууль явагдаж буй байршилд цэргийн цагдаагийн бие бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах зэрэг чиглэсэн үүргийг өглөө.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,269,936 /69.8%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,170,893 /66.7%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,009,379 31,0%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
8026 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
70

ЭДГЭРСЭН
7839

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 398,173,224

Эдгэрсэн

Нийт: 317,743,575

Нас барсан

Нийт: 5,768,936

ЦЭРГИЙН СУРГУУЛИУДЫН СОНСОГЧ, СУРАГЧДАД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ХҮРТЭЭХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү журмын зорилго нь цэргийн сургуулиудын сонсогч, сурагчдын суралцах идэвхийг өрнүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр чадварыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг төлөвшүүлэх, цэргийн албаны сахилга хариуцлагыг өндөржүүлэх, иргэний үүрэг, хариуцлага, хандлага, ёс зүйг төлөвшүүлэх, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

ХОЁР. НЭРЭМЖИТ ШАГНАЛЫН БОЛЗОЛ

- 2.1. Нэрэмжит шагналыг дараах болзлыг хангасан сонсогч, сурагчид хүртээнэ.
 - 2.1.1. Сурлагын амжилтаараа манлайлан 6 улирал дараалан 3.7-гоос доошгүй голч дүнтэй суралцсан байх;
 - 2.1.2. Боловсрол, шинжлэх ухааны болон төрийн захиргааны бусад төв байгууллага, их, дээд сургуулиас зохион байгуулсан оюутны эрдэм шинжилгээний ажил, уралдаан, шалгаруулалтад амжилттай оролцон тэргүүн байруудад шалгарч, сонсогчийн бие даасан 2-оос доошгүй бүтээл /илтгэл, өгүүлэл, оновчтой шийдлийн санал гэх мэт/ гаргасан байх;
 - 2.1.3. Энэхүү журмын 2.1.2-т заасан бие даасан бүтээлийн 1-ээс доошгүй нь цэргийн алба, үндэсний аюулгүй байдлын асуудалд хамаарах сэдвээр хийгдсэн байх;
 - 2.1.4. Цэргийн алба хаагчдын бие бялдрын хөгжил, эрүүл мэндэд тавигддаг стандартын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан, биеийн тамир, цэрэгжлийн спортын уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож амжилт гаргасан байх;
 - 2.1.5. Цэргийн тангараг, дүрмийн шаардлагыг ухамсартайгаар сахин биелүүлдэг, үлгэр жишээч сахилга баттай, иргэний үүрэг, хариуцлага, хандлага, ёс зүйн зөв төлөвшилтэй, анги хамт олондоо нэр хүндтэй байх;
 - 2.1.6. Сургуулийн болон улсын чанартай гадаад хэлний олимпиадад оролцож, тэргүүн байруудад шалгарсан байх.

ГУРАВ. НЭРЭМЖИТ ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ

3.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шагнал нь "ШИЛДЭГ СОНСОГЧ", "ШИЛДЭГ СУРАГЧ" гэсэн төрөлтэй байна.

- 3.1.1. "Шилдэг сонсогч" төрөлд:
 - Үндэсний Батлан хамгаалахын их сургууль,
 - Дотоод хэргийн их сургууль,
 - Тагнуулын академи тус бүрээс 1 /нэг/ төгсөх ангийн сонсогч.
- 3.1.2. "Шилдэг сурагч" төрөлд:
 - Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Тэмүүжин өрлөг сургуулийн 12 дугаар ангийн 1 /нэг/ сурагчийг тус тус шалгаруулна.
- 3.2. Энэ журмын 2.1.2, 2.1.3 дахь заалт сурагчид хамаарахгүй.
- 3.3. Журмын 2.1-д заасан болзлыг бүрэн хангасан сонсогчийн, 2.1.1, 2.1.4, 2.1.5, 2.1.6-д заасан болзлыг хангасан сурагчийн тодорхойлолт, материалыг Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газарт тухайн жилийн 02 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ.
- 3.4. Сонгон шалгаруулах материалд суралцагчийн бие даасан бүтээлд хийсэн эрдэмтдийн дүгнэлт, иргэний үүрэг, хариуцлага, хандлага, ёс зүйн төлөвшлийн талаар болон хамт олны тодорхойлолт зэрэг материалыг хавсаргасан байна.

3.5. Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газар холбогдох материалыг ажлын 10 хоногийн дотор судлан үзэж, холбогдох дүгнэлтийг гарган Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт тухайн жилийн 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

ДӨРӨВ. НЭРЭМЖИТ ШАГНАЛ ХҮРТЭЭХ

- 4.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шагналыг "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Төрийн ордонд хүртээнэ.
- 4.2. "ШИЛДЭГ СОНСОГЧ", "СУРАГЧ" шагнал нь "Өргөмжлөл", мөнгөн шагналаас бүрдэнэ.
- 4.3. Шагнал хүртээхэд Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Тагнуулын академийн захирлуудыг байлцуулж болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧИЙН НЭРЭМЖИТ ЦЭРГИЙН СУРГУУЛИУДЫН ШИЛДЭГ СОНСОГЧ, СУРАГЧИД ХҮРТЭЭХ ШАГНАЛЫН ТӨСӨВ

д/д	Шагналын төрөл	Тоо	Дагалдах мөнгөн шагналын хэмжээ	Нийт дүн / төгрөгөөр/
1	Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн "Шилдэг сонсогч"	1	2.000.000	2.000.000
2	Дотоод хэргийн их сургуулийн "Шилдэг сонсогч"	1	2.000.000	2.000.000
3	Тагнуулын академийн "Шилдэг сонсогч"	1	2.000.000	2.000.000
4	"Тэмүүжин өрлөг" сургуулийн "Шилдэг сурагч"	1	1.000.000	1.000.000
5	Өргөмжлөл	4	50.000	200.000
Бүгд				7.200.000

"АЯЛГУУ" БАГ ТЭРГҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги
Тус анги XVII жарны усан Бар жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан бие бүрэлдэхүүний дунд цахимаар мэндчилгээ, багийн ахлагчийн дуу, гоцлол дуу, хамтлаг дуу гэсэн 4 төрлөөр урлагийн тоглолтуудыг зохион байгуулсан бөгөөд бие бүрэлдэхүүн итгэл сэтгэл гаргаж идэвхтэй оролцлоо. Тэргүүн байрт үлээвэр найрал хөгжмийн "Аялгуу", удаах байрт гал тогоо, уурын зуухны "Есөн эрдэнэ", гутгаар байрт Зенит, миномётын батарейн "Таван эрдэнэ" баг тус тус шалгарлаа.



Монгол цэрэг энхийн үйлсэд

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсэн түүхээс цувралаар товчлон хүргэж байна.

АНХНЫ ЦЭРГИЙН БАГ



Монгол Улсын Засгийн газраас 2003 онд "Иракийн дайны дараах гамшгийг арилгах, сэргээн босголт, тогтворжуулалт, энхийг сахиулах, хүмүүнлэгийн олон улсын ажиллагаанд Зэвсэгт хүчнээс цэргийн баг оролцуулах тухай" тогтоол гаргасны дагуу тус ондоо Зэвсэгт хүчний 150 дугаар ангиас мотобуудлагын ротыг бүрдүүлж, мөн барилгын баг /салаа/-ийг барилгын цэргийн ангиудаас, инженерийн бүлгийг 014 дүгээр ангиас, эмнэлгийн бүлгийг Цэргийн төв эмнэлгээс бүрдүүлэн 186 ЦАХ-ийг сонгон Ирак Улсад үүрэг гүйцэтгүүлэхээр илгээсэн нь Монгол Улс олон улсын болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд анхны цэргийн бага илгээсэн түүхийн эхлэл байв.



Цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүнээс дурдвал цэргийн багийн захирагчаар бэлтгэл хошууч генерал Б.Баярмагнай /дэд хурандаа цолтой/, цэргийн багийн захирагчийн орлогчоор хошууч генерал Ж.Бадамбазар /дэд хурандаа цолтой/, салааны захирагчаар бригадын генерал Ц.Жавхланбаатар, барилгын бүлгийн дарга, инженерээр бэлтгэл хурандаа Ж.Насанжаргал /дэд хурандаа цолтой/ эмнэлгийн бүлгийн даргаар хурандаа Т.Сүхбаатар /дэслэгч цолтой/ нар үүрэг гүйцэтгэв.



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soymbo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)